

ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

**АРВИЖИХ ХК-ИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2023 он

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Лидер экаунт аудит” ХХК

Утас: 88112654, 88472789

Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com



“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2023 оны 3 сарын 29 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
Төмөрчний гудамж - 8, 405 тоот
Утас: +976 7711-4519, 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АРВИЖИХ ХК-ИЙН УДИРДЛАГАД

Дүгнэлт

Бид Арвижих ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Арвижих ХК 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шудрага бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг, хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулагад санал өгөх хангалттай зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг менежентийн захидалд тусгасан болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Арвижих ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Лидер экаунт аудит ХХК
Захирал П.Шаравхорол
2023 оны 03 сарын 29

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АРВИЖИХ ХК-ИЙН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3.1	12,414.00	12,414.00
Дансны авлага	3.2	11,454.00	11,454.00
Татвар, НДШ-ийн авлага	3.3	337,229.07	337,229.07
Бусад авлага	3.4	48,735.00	48,735.00
Бараа материал		-	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3.5	35,000.00	35,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		484,832.07	484,832.07
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3.6	21,973,340.00	21,973,340.00
Биет бус хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрөнгө		21,973,340.00	21,973,340.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		22,458,172.07	22,458,172.07
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	3.7	1,611,610.00	731,610.00
Татварын өр	3.8	1,213,200.00	1,513,200.00
НДШ-ийн өглөг	3.9	71,280.00	71,280.00
Бусад өглөг		89,912,124.00	91,869,624.00
Хүүний өглөг		-	-
Урьдчилж орсон орлого		-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		92,808,214.00	94,185,714.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		92,808,214.00	94,185,714.00
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувийн өмч	3.10	5,638,100.00	5,638,100.00
Хуримтлагдсан ашиг/алдагдал		(75,988,141.93)	(77,365,641.93)
Эзэмшигчдийн өмчийн дүн		(70,350,041.93)	(71,727,541.93)
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		22,458,172.07	22,458,172.07

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

АРВИЖИХ ХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого	3.11	-	880,000.00
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг(алдагдал)		-	880,000.00
Хүүний орлого		-	-
Бусад орлого		-	-
Борлуулалт маркетингийн зардал		-	-
Ерөнхий удирдлагын зардал		-	-
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал	3.12	2,231,552.00	2,257,500.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-	-
Бусад ашиг/алдагдал/		-	-
Татварын өмнөх ашиг(алдагдал)		(2,231,552.00)	(1,377,500.00)
Орлогын татварын зардал	3.13	-	-
Татварын дараах ашиг(алдагдал)		(2,231,552.00)	(1,377,500.00)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		(2,231,552.00)	(1,377,500.00)

2.3 Аудит хийсэн эздийн өмчийн өөрчлөлтийн тайлан

АРВИЖИХ ХК-ИЙН

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,638,100.00	(73,756,589.93)	(68,118,489.93)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	5,638,100.00	(73,756,589.93)	(68,118,489.93)
Тайлант үеийн үр дүн	-	(2,231,552.00)	(2,231,552.30)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,638,100.00	(75,988,141.93)	(70,350,041.93)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	5,638,100.00	(75,988,141.93)	(70,350,041.93)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	(1,377,500.00)	(1,377,500.03)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,638,100.00	(77,365,641.93)	(71,727,541.93)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АРВИЖИХ ХК-ИЙН

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	-	880,000.00
Бараа борлуулсан, үйлчилгээний орлого	-	880,000.00
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	2,231,552.00	2,257,500.00
Хөрөнгийн биржийн хураамжийн зардал	-	500,000.00
Хувьцааны тархалтын мэдээ	-	241,500.00
Зар сурталчилгаа	150,000.00	631,000.00
Бусад	-	585,000.00
Газрын төлбөр	1,481,552.00	-
Үл хөдлөх хөрөнгийн татвар	600,000.00	300,000.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,231,552.00)	(1,377,500.00)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүүний орлого	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	-	-
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-
Зээл, өрийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,231,552.00)	(1,377,500.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,414.00	12,414.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,414.00	12,414.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Үйл ажиллагаа:	Хүнсний ногооны зоорь
Регистрийн дугаар :	2041308
Дүрмийн сан:	5,638,100.0 мянган төгрөг
Компаний хаяг:	Монгол улс, Улаанбаатар, Баянгол дүүргийн 11-р хороо, Зүүн ард Аюуш Ногоон зоорь
Утас:	88400475

ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

1. СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагаа

Баримталсан стандартын талаар: Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (СТОУС) болон Сангийн сайдын 361 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” аргачлалын дагуу бэлтгэсэн. Санхүүгийн тайланг компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

2.1 Санхүүгийн тайланг аккруэль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн

2.2 Бүртгэлийн болон тайлагнах валют

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнахдаа байгууллагын бүртгэлийн валют бөгөөд байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн орчны гол валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн.

ТОДРУУЛГА 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Кассанд байгаа бэлэн мөнгө	12,414.00	12,414.00
Банкны харилцах	-	-
Нийт дүн	12,414.00	12,414.00

3.2 Дансны авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны авлага	11,454.00	11,454.00
	-	-
Нийт дүн	11,454.00	11,454.00

3.3 Татвар, НДШ-ийн авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
НӨАТ-ын авлага	292,229.07	292,229.07
ОАТ-ын авлага	85,000.00	85,000.00
Нийт дүн	377,229.07	377,229.07

3.4 Бусад авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад авлага	48,735.00	48,735.00
Нийт дүн	48,735.00	48,735.00

3.5 Урьдчилж төлсөн зардал/гооцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Урьдчилж төлсөн зардал	35,000.00	35,000.00
Нийт дүн	35,000.00	35,000.00

3.6 Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад үндсэн хөрөнгө	21,973,340.00	21,973,340.00
Хуримтлагдсан элэгдэл		-
Нийт дүн	21,973,340.00	21,973,340.00

3.7 Дансны өглөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны өглөг	1,611,610.00	731,610.00
Нийт дүн	1,611,610.00	731,610.00

3.8 Татварын өр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Үл хөдлөх хөрөнгийн татварын өр	1,200,000.00	1,500,000.00

ОАТ-ын өр	13,200.00	13,200.00
Нийт дүн	1,213,200.00	1,513,200.00

3.9 Бусад өглөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
НДШ-ийн өглөг	71,280.00	71,280.00
Бусад өглөг	89,912,124.00	91,869,624.00
Нийт дүн	89,983,404.00	91,940,904.00

3.10 Эздийн өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,638,100.00	5,638,100.00
Нийт дүн	5,638,100.00	5,638,100.00

3.11 Борлуулалтын орлого болон борлуулалтын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	-	880,000.00
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)		880,000.00

3.12 Бусад зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Хөрөнгийн биржийн хураамжийн зардал	-	500,000.00
Хувьцаа тархалтын мэдээ	-	241,500.00
Зар сурталчилгаа	150,000.00	631,000.00
Бусад	-	585,000.00
Газрын төлбөр	1,481,552.00	-
Үл хөдлөх хөрөнгийн татвар	600,000.00	300,000.00
Нийт дүн	2,231,552.00	2,257,500.00

3.13 Орлогын татварын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Орлогын татварын зардал	-	-
Нийт дүн	-	-

3.14 Балансын дараах үйл явдал

2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хүртэл Арвижих ХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулах шаардлагатай үйл явдал гараагүй байна.

Аудитор  Ч.Отгонцэцэг

2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр